

МБС-ЫН МАГИСТР БАГШ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ИРГЭДИЙН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Мэргэжлийн боловсрол, сургалтын Магистр багш бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төвөөс хөтөлбөрт хамрагдах иргэдийн тандалт судалгааг зохион байгууллаа.

Судалгаа нь урьдчилан гаргасан удирдамжийн дагуу, дараах сегментийн хүрээнд явагдсан.

Судалгааны хамрсан хүрээ: Эрчим хүч, Барилга, Аж үйлдвэрийн салбарын мэргэжлүүдээр мэргэшиж суралцах, боловсролын Магистр зэрэг хамгаалах эрэлт хэрэгцээ бүхий нийт 753 хүнийг хамруулсан. Үүнд:

1. МСҮТ, ПК болон түр сургалтын байгууллагын багш нар - 173
2. Үнэлгээ баталгаажуулалтын ажилтан - 6
3. ААНБ, үйлдвэрт одоо ажиллаж буй залуу инженер техникийн ажилтнууд - 344
4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй, инженер мэргэжилтэй иргэд - 206
5. Инженер мэргэжлээр төгсөх курст суралцаж байгаа оюутан, төгсөгчид - 26

Судалгааны арга зүй:

Судалгаанд хамрагдсан 5 зорилтот бүлгээс мэдээлэл цуглуулах сувгийг тодорхойлон гүүглформ аппликэйшн ашиглан асуулгын аргаар явуулсан. Судалгааг зохион байгуулахад Барилгын, эрчим хүчний, аж үйлдвэрийн мэргэжлийн зөвлөлүүд, ААН байгууллага, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, ШУТИС-ийн бүрэлдэхүүн 5 сургууль хамтран ажилласан.

Судалгааг зохион байгуулсан хугацаа:

- Судалгааны асуулга хүргүүлэх, мэдээлэл цуглуулах 2021.02.01 -- 02.15 хүртэл
- Судалгааны мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх 2021.02.15 -- 02.20

Судалгааны зохион байгуулалт, төлөвлөлт:

Судалгааны явцыг бид дараах байдлаар, 650 хүнийг хамруулах бөгөөд тэдгээрийн 30%-ийн (195 хүн) үр дүнг бүрэн дүүрэн хариулах магадлалтай хэмээн төсөөлсөн боловч судалгаанд оролцогчдын тоо 753 ба нийт идэвхтэй хариултын тоо 80 орчим хувьтай байлаа.


Анхны төлөвлөлт ба төсөөлөл:

- Судалгаа үргэлжлэх 14 хоногийн хугацаанд мэдээллийн сувгийг байнга идэвхжүүлэх бөгөөд судалгааг дараах байдлаар зохион байгуулна.

№	Зорилтот бүлэг	Хамрагдах магадлал	Сувгийг хариуцах,
1	МБСБ-ын багш нар	100	МБСҮМАЗТ МБСҮМАЗТ, Багшийн хөгжил, Үнэлгээ гэрчилгээжүүлэлтийн арга зүйчид, зохион байгуулалтад Зөвлөхөөр Д.Дэлгэрмаа
	ПК-ийн төгсөгчид /2020-2021 оны төгсөгчид/	100	
	Мэргэжлийн сургалтын байгууллагын багш нар ИТА	50	
2	Мэргэжлийн зөвлөл	50	
	Үнэлгээний ажилтнууд, дадлагажуулагч багш нар	50	
3	ААНБ-ын залуу ИТА, тэтгэвэрт гарахаар зэхэж буй ИТА, ГИЗ-ийн үйлдвэрлэлийн дадлагажуулагч нар	100	ГИЗ Холбогдох байгууллагуудтай хамтрах
4	ШУТИС төгсөгчид	100	
5	Ажилгүйдэлд бүртгэлтэй иргэд	50	
	Магистер багшийн хөтөлбөрийн танилцуулга бэлтгэх		
	650 (хамгийн багадаа 30% =195) хүн хамрагдах		

Судалгааны үр дүн:

Нийт судалгаанд оролцогчидыг ажиллаж буй салбараар ангилж харвал:




Хариулаагүй	27	4%
МБСБ	78	10%
Салбар дунд	11	1%
Аж үйлдвэр	182	24%
Барилга	104	14%
эрчим хүч	327	43%
Төгсөгчид ба оюутнууд	24	3%
Нийт	753	100%

Оролцогчдын 86%-ийг магистрийн сургалтыг зохион байгуулах гол чиглэл болж буй 3 салбарын хүрээнд, тухайн салбаруудад ажиллаж байгаа, мөн тус салбарын мэргэжилтэй инженерүүд эзэлж байна. Үүнээс магистрийн хөтөлбөрт элсэгчдэд тавьж буй ерөнхий үзүүлэлтэд нийцэхгүйц хүмүүс судалгаанд хамрагдсан гэж үзэж магадлал өндөр байна.

Тэднийг боловсролын зэргээр ангилвал Бакалавр 526 буюу 70%, магистр 184 буюу 24%, бусад болон төгсөх курсын оюутан 42 буюу 6% байна. Магистр зэрэгтэй

иргэдийн хувьд МБС-ын салбарт дахин магистрийн хөтөлбөрт хамрагдах багшлах сонирхол байна гэж харж болохоор байна.

Оролцогчдын МБС-ын салбарын талаарх мэдлэг, ойлголтыг тандахад огт холбогдож байгаагүй болон хариулаагүй байдал 46%-ийг эзэлж байна. Тал хувь нь МБС-ын салбарын талаар төдийлөн сайн мэдэхгүй боловч, судалгаанд оролцсоноос харвал боловсролын “магистр” зэргийг илүү сонирхсон байж болох магадлалтай.



МБС-ын салбарт багшлахын давуу тал болон ач холбогдлыг дараах байдлаар ойлгодог бөгөөд хамгийн чухал гэж хариулсан байдлаар эрэмбэлэн харуулав.

Энэ хэсгийн үзүүлэлтээс харахад урьдчилан тооцоолж байсан (инженерүүдийн хувьд цалин болон байршлыг илүү сонгох..) үр дүн, таамаглалаас өөр үр дүн үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл инженерүүд, багш нар МБС-ын магистрийн хөтөлбөрт хамрагдсанаар хөгжих боломж, ажиллах орчин нөхцөл, хүүхэд залууст зөвлөж, зааж сургахыг илүү чухалд үзсэн байна. Үүнээс харахад өнөөгийн залуус болон инженер техникийн ажилтнууд нь

1	Хөгжих боломж	233
2	Ажиллах орчин нөхцөл	193
3	Хүүхэд, залууст зөвлөж, зааж сургах	181
4	Цалин	180
5	Тогтвортой ажиллах	163
6	Багшлах туршлага хуримтлуулах	162
7	Байршил	95

мэргэжлийн боловсрол, сургалтад өндөр ач холбогдол өгч, тус салбарыг цаашид суралцах, хөгжих, мэргэжлийн үр чадвар, боловсролын зэргээ дээшлүүлэх боломж гэж харж байна гэсэн дүгнэлт өгч болохоор байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт багшлах сонирхолын үзүүлэлт нь 45% нь тийм, 28% нь үгүй, 27% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл МБС-ын салбарт багшлах сонирхол 50% орчим байна.

Харин МБС-ын магистр багшаар бэлтгэгдэх сонирхолын хувьд 56% тийм, 19% үгүй, 25% хариулаагүй байна. Магистрийн хөтөлбөрийн үр дүн, ач холбогдол, дэлгэрэнгүй танилцуулгаас хамаараад тэдний суралцах сонирхол нэмэгдэх магадлалтай юм.

Магистрын хөтөлбөрт тусгайлан цаг гаргаж суралцах боломжтой гэж 229 буюу 30% нь хариулсан бол ажлын байрандаа суралцах хүсэлтэй 56% байна. Энэ нь

магистрийн хөтөлбөрийг уян хатан зохион байгуулах шаардлага гарч болзошгүйг харуулж байна.

МБС-ын магистр багшийн хөтөлбөрт хамрагдсаны дараах тэдний төсөөллийн тандалтыг бүлэглэн авч үзвэл:

- Цаашид тогтвортой ажиллах, үргэлжүүлэн багшлах, инженерийн ур чадвар нэмэгдэх
- Мэдлэг ур чадвар нэмэгдэх, өөрийгөө хөгжүүлэх
- Залуу хүний хувьд өөрийгөө хөгжүүлэх, заах арга барил болон мэргэжлийн болоод бусад ур чадвараа дээшлүүлэх
- Байгууллагынхаа сургалтын хэлтэс ажиллаж, сургалтын чанарыг дээшлүүлэх
- Ажлын байрандаа хөгжих, тогтвортой ажиллах
- Хувийн сургалтын төв ажиллуулах
- Дэлхийд өрсөлдөхүйц ур чадвартай Мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд, МБС-ыг хөгжүүлэх, мэргэжлийн сургалтын чанарт ахиц гаргах, төгсөгчдийн үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн боловсролын чиглэлээр судалгаа хийх
- Их дээд сургуульд багшлах
- Мэргэшсэн инженер болох
- Цаашид докторын зэрэгт суралцах
- Залуу үед мэргэжлийн туршлагаасаа хуваалцах

Судалгаанд оролцогчдын 49% буюу 371 инженер техникийн ажилтнууд, МБСБ багш нар магистрийн хөтөлбөр эхлэхэд суралцах сонирхолтойгоо илэрхийлсэн бөгөөд эргэн холбогдох хаяг, утасны дугаараа үлдээсэн болно.

Дүгнэлт

Судалгаанаас харахад нийт оролцогчдын 50 орчим хувь буюу 370 гаруй инженер техникийн ажилтнууд, МБС-ын салбарт ажиллаж буй инженер мэргэжилтэй багш нарын хувьд МБС-ын магистр багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй байна. Тэд энэхүү хөтөлбөрт хамрагдсаны ач холбогдолыг өөрийгөө хөгжүүлэх боломж, хүүхэд залууст зөвлөн туслах, туршлагаасаа хуваалцах, МБС-ын салбарын судалгаа шинжилгээг хөгжүүлэх, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэх, боловсролын зэрэг ахиулах гэсэн зорилго биелэнэ гэж үзэж байна. Оролцогчдын хандалтаас харахад тэдэнд тохирсон сонголтот болон тохируулгат, модульчилсан, хугацааны хувьд уян хатан, кредит дүйцүүлэх боломжтой байдлаар хөтөлбөрийг зохион байгуулах, өөрөөр хэлбэл насан туршийн боловсролын бодлого механизмыг хэрэгжүүлэх нь сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, иргэдийн сонирхол хэрэгцээнд нийцэх, МБС-ын салбарын эрэлт хэрэгцээг тохиромжтой хугацаанд хангах боломж олгоно.

Энэхүү судалгаа нь зөвхөн 3 салбарын хувьд эрэлтийн тандалтыг хийсэн. Цаашид эдийн засгийн бүх салбаруудын хувьд, эсхүл МБС-аар бэлтгэдэг мэргэжлүүдийн хүрээнд тандалт судалгааг зохион байгуулвал илүү олон эрэлтийг тодорхойлох боломжтой байна.